

7 хоногийн мэдээ

1. ЭМГазрын даргын батлагдсан удирдамжын дагуу Нэгдсэн эмнэлгийн өрөх тасагт Эх нярайн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламжийн чанар, сувилахуйн тусламж үйлчилгээ, халдварт хамгаалалын шиглэлээр дэмжлэгт хяналт - шинжилгээ үнэлгээний баг 3 өдөр ажиллав.
2. Дархлаажуулалтын жилийн эцсийн тайлан болон А витамин хэрэглээний мэдээг сум дундын эмнэлэг, сумөрх, тосгоны ЭМТ - үүдийн вакцинаруудаас нэгтгэн авч, ӨХҮТ болон НЭМҮТ -д цахимаар мэдээлсэн. Дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын жилийн эцсийн тайланг гаргаж, ХӨСҮТ-д цахимаар хүргүүлсэн.
3. 2018 оны 4 дүгээр улиралд эндсэн нярайн тохиодлыг магадлан хэлэлцэх хурлыг Эрүүл мэндийн газар зохион явууллаа. Уг хуралд зөвлөлийн дарга, гишүүд, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн болон эндэгдэл гарсан Ногооннуур сумын Чихтэйн багийн их эмчийн салбар, Булган сумын ЭМТ, Мейрим, Шипагер Өрхийн ЭМТөвийн холбогдох эмч, мэргэжилтэнгүүд оролцлоо. Тохиолдол бүрийг авч хэлэлцэж алдаа оноогоо дүгнэж шийдвэр гаргалаа.
4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд жирэмсэн эхийн хяналтын чанарыг сайжруулах, аль ч шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай цаг алдалгүй үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулахад анхаарч ажиллахыг үүрэг болгов. Булган сум, Мейрим өрхийн ЭМТөвийн холбогдох эмч, эх баригч нарыг ЭМГазрын даргын зөвлөлд оруулахаар шийдвэрлэв.
5. 2019 оны 1 дүгээр сарын 07, 08, 09, 10 -ны өдрүүдэд угаарын хийн Өлгий сумын 8,9,10, 12 дугаар багуудаас нийт 5 тохиолдол бүтгэгдэж нийт 17 хүн угаардаж тандалт судалгаа хийж Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд тандалтын мэдээний тайланг хүргүүлж, өрхийн эмчийн хяналтанд шилжүүлэн ажилласан. Хүмүүсийн биеийн байдал нь сайжирсан байна.
6. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн Саян, Дербес нэврүүлгээр хүргүүлсэн.
7. Дархлаажуулалтын жилийн эцсийн тайлан болон А витамин хэрэглээний мэдээг сум дундын эмнэлэг, сумөрх, тосгоны ЭМТ - үүдийн вакцинаруудаас нэгтгэн авч, ХӨСҮТ болон НЭМҮТ-д цахимаар мэдээлсэн.
8. Дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын жилийн эцсийн тайланг гаргаж, ХӨСҮТ-д цахимаар хүргүүлсэн.
9. “Агаарын бохирдол ба эрүүл мэнд”, “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлье” сэдвээр “ Монгол заман сонин ” -д мэдээлэл нийтлүүлсэн.

10. Томуугийн вирусийн хүрээг тодорхойлох зорилгоор шинжилгээ хийлгэхээр 2019 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн НЭ-ийн хүүхдийн тасагаас 5 хүүхэдээс хамрын арчдасын шинжилгээг авч Ховд аймгийн БОЭТ-д хүргүүлсэн. Хариуг тухайн үед бүх нэгжүүдэд танилцуулж эргэн мэдээлж, Томуу, томууст өвчний өвчлөлийн тохиолдол, түүний хүндрэл нэмэгдэх хандлагатай байгаатай холбогдуулан Томуу, томууст төвчний талаар эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтнуудын баримтлах зарчим, анхаарах зүйлсийн талаарх зөвлөмжийг харьяа байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.
11. “Өсвөр насны онцлог ба эцэг эхийн анхаарал” сэдвээр орон нутгийн радио, “Монгол заман” сониноор мэдээлэл нийтлүүлсэн.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 36

Амьд төрөлт - 36

Амьгүй төрөлт- 0

Дутуу төрөлт - 3

Нялхсын эндэгдэл- 1

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-0

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 0

Гэрийн төрөлт- 2

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжид 01 дүгээр долоо хоногт нийт 3153 хүн үйлчлүүлсний 214 (6.7%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 2,3%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (328)-ийн дотор 52 буюу 15,8 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 6,8 %-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 360 дуудлагын 81 (22,5 %-ийг ГТӨ -ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад адилхан үзүүлэлтэй байна.